

Боловсруулалт хийгдэж байгаа



ИНД-119

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ

**АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ-
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ**

Иргэний нисэхийн ерөнхий газар

Дүрмийн тайлбар

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-199-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-119, түүний өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.
Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/ -ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-119 нь **анх 2016 оны 3 дугаар сарын 1**-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд дараах өөрчлөлтийг багтаасан:

Өөрчлөлтийн дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо
---------------------------	------------------------------------

Өөрчлөлт 1	20... оны ... сарын
------------	---------------------------

ИНД-119-ийг Шинэ Зеландын Part 119, 2015 оны 9-р сарын 24-ний өдрийн өөрчлөлт-д үндэслэн боловсруулсан болно.

Тэмдэглэл: ИНД-119-ийг англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбар нь давамгайлна.

Гарчиг

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	7
119.1. Зорилго.....	7
119.3. Тодорхойлолт.....	7
119.5. Гэрчилгээнд тавигдах шаардлага.....	8
119.7 Нөөц.....	8
119.9. Өргөдөл гаргах.....	8
119.11. Гэрчилгээ олгох.....	9
119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх	9
119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт.....	10
119.17. Гэрчилгээний хугацаа.....	11
119.19. Үйл ажиллагаагаа зогсоох мэдэгдэл	11
119.21. Гэрчилгээний хугацааг сунгах.....	11
Б БҮЛЭГ. ИНД 121-ИЙН ДАГУУ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АРИЛЖААНЫ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	11
119.51. Боловсон хүчинд тавигдах шаардлага.....	11
119.53. Мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагууд	13
119.55. Хангамжид тавигдах шаардлагууд	13
119.57. Үзүүлэх буюу шалгах нислэг	14
119.59 Нөөц.....	14
119.61. Техник үйлчилгээний журмууд.....	14
119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр.....	15
119.64. Нислэгийн аюулгүй ажиллагааны бичиг баримтын тогтолцоо/ Flight safety documents system	16
119.65. Баримт бичиг.....	16
119.67. Боловсон хүчний бүртгэл	17
119.69. Тоног төхөөрөмжийн хангалтын тухай бүртгэл.....	18
119.71. Нислэгийн зөвшөөрөл ба хяналт	18
119.73. Нислэгийн хяналтын үйлчилгээ	18
119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүй байдлын хөтөлбөр.....	19
119.77. Үйл ажиллагааны журам тогтоох	19
119.79. Аюулгүй ажиллагааны удирдлага.....	19
119.81. Арилжааны агаарын тээвэрлэгчийн байгууллагын ерөнхий зааварт тавигдах шаардлага	19
В БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА	21
119.101. Боловсон хүчинд тавигдах шаардлага.....	21
119.103. Мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагууд	22
119.105. Хангамжид тавигдах шаардлагууд	23
119.107 Шалгах нислэг эсхүл туршилтууд.....	24

119.61. Техник үйлчилгээний журмууд	24
119.111 Техник үйлчилгээний хөтөлбөр.....	24
119.113. Баримт бичиг.....	25
119.67. Боловсон хүчний бүртгэл	26
119.117. Тоног төхөөрөмжийн хангалтын тухай бүртгэл.....	27
119.119. Нислэгийн зөвшөөрөл ба хяналт	27
119.121. Нислэгийн хяналтын үйлчилгээ	27
119.123. Үйл ажиллагааны журам тогтоох	28
119.124. Аюулгүй ажиллагааны удирдлага.....	28
119.125. Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн байгууллагын ерөнхий зааварт тавигдах шаардлага	28
Г БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА	30
119.151. Нийцлийн хадгалалт.....	30
119.153. Нислэгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага	30
119.155. Нисэх багийн мэргэшил.....	31
119.157. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслэх, хөлслөх болон захиалгат нислэг үйлдэх.....	31
119.159. Монгол Улсад бүртгэлгүй агаарын хөлгийг ашиглах.....	32
119.161. Хууль ёсны нэр болон бизнесийн нэр	32
119.163. Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд.....	33
119.165. Гэрчилгээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орох	33
119.167. Техник үйлчилгээний хөтөлбөрийг өөрчлөх.....	34
БҮЛЭГ Д ШИЛЖИЛТИЙН НӨХЦӨЛ.....	34
119.201 ИНД-121 эсхүл ИНД-125-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны агаарын тээвэрлэгчийн шилжилтийн нөхцөл.....	34
119.203 ИНД-135-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн шилжилтийн нөхцөл	36
119.205 агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт	37
119.207 Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт	39
119.209 ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт	41
ХАВСРАЛТ "А". АРИЛЖААНЫ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА.....	42
A.1 Агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан	42
A.2 Нисэх багийн ур чадвар, сургалтын үнэлгээ хариуцсан удирдах албан тушаалтан.....	43
A.3 Техник үйлчилгээг удирдах, хянах удирдах албан тушаалтан.....	44
A.3.1 ИНД-121-ийн үйл ажиллагаа	44
A.3.2 ИНД-125-ийн үйл ажиллагаа	45
A4. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтан	

46

ХАВСРАЛТ "Б". ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД
ТАВИГДАХ ШААРДЛАГА 46

В.1 Агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан47

В.2 Нисэх багийн ур чадвар, сургалтын үнэлгээ хариуцсан удирдах албан тушаалтан48

В.3 Техник үйлчилгээг удирдах, хянах удирдах албан тушаалтан.....48

В.4 Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтан

49

А БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

119.1. Зорилго

(а) Энэ дүрмээр ИНД-121, ИНД-125 болон ИНД-135-ын дагуу агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, байгууллагыг гэрчилгээжүүлэх болон тэдгээрийн тогтмол үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтооно.

(b) Хамааралгүй

119.3. Тодорхойлолт

Энэ дүрэмд:

Арилжааны агаарын тээвэрлэгчийнгэрчилгээгж дараах агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах эрх олгож буй баримт бичгийг:

- (1) ИНД-121-ийн дагуушаардлагатай нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 30 ба түүнээсдээш зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410 кг-аасдээш онгоцоор агаарынтээврийн үйл ажиллагаа; эсхүл,
- (2) ИНД-125-ийн дагуу шаардлагатай нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10-аас 30 хүртэлх зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410 кг буюу түүнээсдоош болон Хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг-аасдээшонгоцоор агаарынтээврийн үйл ажиллагаа; эсхүл,
- (3) ИНД-125-ийн дагуу ГХХНД/SEIFR ганц хөдөлгүүртийн-хэрэглэлийн нислэгийн дүрмээр явуулах зорчигч тээврийн үйл ажиллагаа; эсхүл,
- (4) ИНД-135-ын дагуу шаардлагатай нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 9 буюу түүнээс цөөн тооны зорчигчийн суудалтай, болон Хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг-аас буюу түүнээсдоош эсхүл нисдэг тэрэг ашиглан ГХХНД/SEIFR /-ээр зорчигч тээврийн үйл ажиллагаанаас бусад агаарынтээврийн үйл ажиллагаа.

Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээгж арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эсхүл ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг хэлнэ:

Байгууллагын үйл ажиллагааны ерөнхий зааваргж энэ дүрэмд өөрөөрзаагаагүй бол 119.81, эсхүл 119.125-д шаардсан гэрчилгээ эзэмшигчийн үйлажиллагаандаа мөрдлөг болгох баримт бичгийг.

Ерөнхий зориулалтыннислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ гэж ИНД-135-ын дагуу шаардлагатай нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 9 буюу түүнээс цөөн тооны зорчигчийн суудалтай, болон Хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг-аас буюу түүнээсдоош эсхүл нисдэг тэрэг ашиглан ГХХНД/SEIFR /-ээр зорчигч тээврийн үйл ажиллагаанаас бусад агаарынтээврийн үйл ажиллагаа.

119.5. Гэрчилгээнд тавигдах шаардлага

(а) Агаарын тээврийн үйл ажиллагааны талаар үүрэг хүлээсэн этгээд нь энэ дүрмийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг эзэмшиж, дагаж мөрдөн үйл ажиллагаагаа явуулна.

(b) Сонирхогчийн нисэхийн үйл ажиллагаа явуулахаас бусад тохиолдолд Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль болон энэ дүрмээр олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний дагуу болон зохих эрхийн хүрээнээс бусад агаарын тээврийн үйл ажиллагаа явуулахыг аливаа этгээдэд хориглоно.

(c) Хэрэв тухайн этгээд нь дараах үйл ажиллагааны чиглэлээр хоёр болон түүнээс дээш үүрэг хүлээж байвал энэ зүйлийн (a)–д заасан үүрэг хүлээсэн этгээд гэж ойлгоно:

- (1) Үйл ажиллагаа аюулгүй явагдах эсэх талаарх шийдвэр гаргах;
- (2) Үйл ажиллагаанд оролцох нисэх багийг томилох;
- (3) Үйл ажиллагаанд оролцох нисэх багийг үндсэн, эсхүл гэрээгээр болон бусад хэлбэрээр ажилд авах;
- (4) Агаарын хөлгийн дарга аюулгүй ажиллагаанд үндэслэн гаргасан шийдвэрээс бусад үйл ажиллагааг өөрчлөх шийдвэр гаргах.

119.7 Нөөц

119.9. Өргөдөл гаргах

(а) Өргөдөл гаргагч бүр нь дараах мэдээллийг шаардсан маягт САА 24119/01-ыг бөглөж Даргад ирүүлнэ:

- (1) Монгол Улсад үйл ажиллагаа явуулах өргөдөл гаргагчийн нэр, хаяг; болон,
- (2) энэ дүрмийн 119.15-ын (b)-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтод шаардагдах дэлгэрэнгүй мэдээлэл; болон,
- (3) Энэ дүрмийн дараах заалтаар шаардсан байгууллагын ерөнхий заавар:
 - (i) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хувьд ИНД-119.81 заалтаар,
 - (ii) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний хувьд ИНД-119.125 заалтаар; болон,
- (4) Дарга шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчаас маягтад тусгагдсан асуулгыг тодорхой болгох үүднээс нэмэлт тодруулгыг шаардаж болно.

(b) Дарга өөрөөр тогтоогоогүй бол өргөдөл гаргагч төлөвлөсөн агаарын тээврийн үйл ажиллагаагаа эхлэхээс 90-ээс доошгүй хоногийн өмнө төлбөрийн баримтын хамт Даргад ирүүлсэн байна.

119.11. Гэрчилгээ олгох

(a) Дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно:

- (1) энэ дүрмийн Бүлэг "Б"-гийн шаардлагыг хангасан; болон,
- (2) Өргөдөл гаргагч нь хувь хүн бөгөөд өргөдөл гаргагчийн удирдах албан тушаалтнууд энэ дүрмийн 119.51(a)(1) ба (2)-т заасан шаардлагуудыг хангасан; болон,
- (3) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх; болон,
- (4) Хамааралгүй.

(b) Дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид ИНД-135-ийн дагуу агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно:

- (1) энэ дүрмийн Бүлэг "В"-гийн шаардлагыг хангасан; болон,
- (2) Өргөдөл гаргагч нь хувь хүн бөгөөд өргөдөл гаргагчийн удирдах албан тушаалтнууд энэ дүрмийн 119.101(a)(1) ба (2)-т заасан шаардлагуудыг хангасан; болон,
- (3) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.

119.13. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

(a) Гэрчилгээ нь тухайн гэрчилгээ эзэмшигчийн зөвшөөрөгдсөн агаарын тээврийн үйл ажиллагааны эрхийг тодорхойлно.

(b) Гэрчилгээнд гэрчилгээ эзэмшигчийн дараах үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг тусгасан байна:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн гэрчилгээнд заасан агаарын тээврийн үйл ажиллагаа; болон,
- (2) Үйл ажиллагаа явуулах болон явуулж байгаа агаарын хөлгийн газрын эсхүл нислэгийн зохих сургалт; болон,
- (3) нисэх багийн ур чадварыг тодорхойлох шалгалтын эсхүл туршилтын нислэг; болон,

- (4) гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын ерөнхий зааварт тодорхойлсон бусад үйлчилгээ үзүүлэгч этгээдийн ур чадварыг тодорхойлох шалгалт эсхүл туршилт.

119.15. Үйл ажиллагааны тодорхойлолт

(a) Хууль болон энэ дүрмийн дагуу олгосон Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд энэ зүйлийн (b)-д заасан "Үйл ажиллагааны тодорхойлолт"-ыг хавсаргасан байна.

(b) "Үйл ажиллагааны тодорхойлолт" нь дараах мэдээллийг агуулна:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах үндсэн байршлын дэлгэрэнгүй; болон,
- (2) гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улс дахь албан ёсны нэр болон хаяг; болон,
- (3) үйл ажиллагаагаа өөр бизнес нэрийн дор явуулах бол тухайн нэр, хаяг; болон,
- (4) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлөг бүрийн маяг, улсын бүртгэлийн болон үйлдвэрийн дугаар; болон,
- (5) агаарын тээврийн зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны төрлийн дэлгэрэнгүй; болон,
- (6) үйл ажиллагаа явуулах бүс нутаг, нислэгийн чиглэлийн зөвшөөрөл болон хязгаарлалтууд; болон,
- (7) зөвшөөрөгдсөн тусгай зөвшөөрлийн дэлгэрэнгүй; болон,
- (8) тухайн нөхцөл байдлыг хамруулсан Дарга шаардлагатай гэж үзсэн аливаа бусад зүйл; болон,
- (9) Хамааралгүй;

(c) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод ГХХНД/SEIFR ганц хөдөлгүүртийн-хэрэглэлийн нислэгийн дүрмээр зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо Дарга тус зөвшөөрлийн хугацааг Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд заасан хүчинтэй хугацаанаас багаар тогтоож болно.

(d) Дарга АХСН - Алслалтын хугацааг сунгасан нислэг (EDTO) үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгохдоо Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтод дараах зүйлийг тусгахыг шаардана:

- (1) EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн онгоц тус бүрийн бүртгэлийн дугаар; болон,

- (2) (1)-д заасан агаарын хөлөг бүрийн алслалтын хугацааг сунгасан нислэгийн хамгийн их хугацаа; болон,
- (3) EDTO үйл ажиллагаанд зөвшөөрөгдсөн нөөц аэродромууд.

119.17. Гэрчилгээний хугацаа

- (a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаагаар олгох буюу хугацааг сунгаж болно.
- (b) Гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, эсхүл Дарга гэрчилгээг түр түдгэлзүүлэх буюу хүчингүй болгохоос бусад тохиолдолд гэрчилгээ нь хүчин төгөлдөр байна.
- (c) Гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.
- (d) Гэрчилгээг түр түдгэлзүүлсэн тохиолдолд гэрчилгээ эзэмшигч холбогдох зөвшөөрөл болон цаашид авах арга хэмжээнд зориулан гэрчилгээг Даргад ирүүлнэ.

119.19. Үйл ажиллагаагаа зогсоох мэдэгдэл

Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд энэ тухайгаа 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад бичгээр мэдэгдэнэ.

119.21. Гэрчилгээний хугацааг сунгах

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг САА 24119/01маягтын дагуу гаргана.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан өргөдлийг гэрчилгээ эзэмшигчнь гэрчилгээнд заасан өргөдөл гаргах хугацаанаас, өмнө эсхүл гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлсэн байх ёстой.

Б БҮЛЭГ. ИНД 121-ИЙН ДАГУУ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ АРИЛЖААНЫ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

119.51. Боловсон хүчинд тавигдах шаардлага

- (a) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дараах эрх, үүрэг бүхий албан тушаалтнуудыг үндсэн, гэрээгээр болон бусад хэлбэрээр ажиллуулна:
 - (1) гүйцэтгэх захирлын үүрэг хүлээсэн удирдах албан тушаалтан нь:

- (i) өргөдөл гаргагч байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа бүр нь энэ дүрэмд заасан шаардлага болон стандартуудын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах; болон,
 - (ii) энэ дүрэмд заасан шаардлага бүрийг байгууллага нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгааг бататгах үүргийг тус тус хүлээх; болон,
- (2) бусад удирдах албан тушаалтан нь:
- (i) байгууллагын ерөнхий зааврыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэг хүлээх; болон,
 - (ii) энэ зүйлийн (b) хэсгийн (1)-д заасан, хамаарах үйл ажиллагааны хувьд хариуцлага хүлээх; болон,
 - (iii) гүйцэтгэх захирлын өмнө шууд хариуцлага хүлээх; болон,
- (3) байгууллагын ерөнхий зааварт тодорхойлогдсон үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон баталгаажуулахад хүрэлцэхүйц тооны гүйцэтгэх ажилтантай байна.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан удирдах албан тушаалтнууд нь:
- (1) ИНЕГ-ын дарга, өргөдөл гаргагчийн явуулах гэж буй агаарын тээврийн үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан өөрөөр тогтоогоогүй бол дараах үйл ажиллагаа тус бүрийг хариуцсан удирдах албан тушаалтантай байна:
 - (i) нислэгийн болон газрын үйлчилгээний үйл ажиллагаа оролцуулсан агаарын тээврийн үйл ажиллагааг хариуцсан:
 - (ii) нисэх багийн сургалт, болон ур чадварын үнэлгээ хариуцсан:
 - (iii) техникүйлчилгээг хянах болон хувиарт төлөвлөлтхариуцсан:
 - (iv) ИНД-119.79 –д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан:
 - (v) ИНД-119.75 –д шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр шаардлагатай тохиолдолд агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлыг хариуцсан:
 - (vi) ИНД-12-д заасны дагуу осол, зөрчлийг шинжлэн шалгахүйл ажиллагаа гүйцэтгэх; болон,
 - (2) Удирдах албан тушаалтан нь хүлээсэн үүрэгт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах,энэ дүрмийн Хавсралт А-д заасан мэргэшил, дадлага туршлага эзэмшисэн гэдгийг бататгасан байна.

(c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-д заасныг үл харгалзан Өргөдөл гаргагчийн агаарын тээврийн үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан (b)(1)(i)хэсэгт заасан агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан болон нисэх багийн ур чадварын үнэлгээхариуцсан удирдах албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэгтгэж болно.

(d) ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрсөн тохиолдолд удирдах албан тушаалтан нь энэ зүйлийн (b) хэсгийн 1/-д заагдсан аль нэг үүрэгт ажлыг өөр этгээдэд зохих нөхцөлөөр шилжүүлэн гүйцэтгүүлж болох боловч тухайн үйл ажиллагааны төлөө хүлээх хариуцлага нь удирдах албан тушаалтанд хэвээр хадгалагдана.

119.53. Мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагууд

(a) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:

- (1) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан агаарын тээврийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, баталгаажуулах, хянах, эсхүл гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны анхан шатны суурь мэдлэгийг дүгнэх болон тэдгээрийн мэргэжлийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэх; болон,
- (2) эрх, үүргийн хүрээг тодорхойлсон бичгээр гаргасан баталгаагаар эрх бүхий ажилтнууд хангагдсан гэдгийг бататгах.

(b) Энэ зүйлийн (a)-ийн (1)-д заасан ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг шалгаж үнэлгээ өгөх, эсхүл ур чадварыг хадгалах болон дээшлүүлэх сургалт дадлагыг зохион байгуулах эрх бүхий ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагатай өргөдөл гаргагч гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b) хэсэгт заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд өргөдөл гаргагч нь байгууллагын ерөнхий заавартаа дараах мэдээллүүдийг дэлгэрэнгүй тусгасан байна:

- (1) гэрээт байгууллагад шилжүүлсэн эрх, үүрэг; болон,
- (2) гэрээт байгууллагын явуулах сургалт дадлага болон шалгалтын хүрээ; болон,
- (3) гэрээт байгууллагын сургалт, дадлага болон шалгалт авахтай холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл.

119.55. Хангамжид тавигдах шаардлагууд

(a) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц дараах хангамжтай байна:

- (1) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан үйл ажиллагааг явуулах хангалттай нөхцөл бололцоотой байх; болон,
- (2) тэдгээр нь дараах зүйлийг багтаасан байна:
 - (i) албан өрөө, тасалгаатай ажлын байр, засвар үйлчилгээний цех, ангар болон техник үйлчилгээний барилга байгууламж; болон,
 - (ii) үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сэлбэг материал сургалтын хэрэгслүүд болон мэдээллүүд, баримт бичиг.

(b) Өргөдөл гаргагчийн ажлын байрны хүрээлэн буй орчин нь дараах нөхцөлийг хангасныг бататгана:

- (1) ажил, үүргээ гүйцэтгэхэд тохиромжтой байх; болон,
- (2) цаг агаарын тааламжгүй аливаа нөхцөлөөс хамгаалагдсан байх.

119.57. Үзүүлэх буюу шалгах нислэг

(a) Гэрчилгээ эзэмшихээр, эсхүл гэрчилгээндээ нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөдөл гаргагч нь Дарга шаардсан тохиолдолд аливаа хамаарал бүхий тогтоогдсон шаардлагуудыг хангаж байгааг нотлох шалгах нислэг буюу туршилтуудыг үйлдэнэ.

(b) шалгах нислэг буюу туршилтуудыг Даргын хүлээн зөвшөөрсөн аргачлалаар гүйцэтгэнэ.

119.59 Нөөц

119.61. Техник үйлчилгээний журмууд

(a) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах агаарын хөлөг болон тоног төхөөрөмжийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг баталгаажуулах журмыг тогтоосон байна:

- (1) гэрчилгээний олгогдсон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлөг тус бүрийн; болон,
- (2) агаарын хөлөгт суурилуулсан болон бэхлэгдсэн аливаа тоног төхөөрөмж тус бүрийн.

(b) агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсэгч нь өөрийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлэх бол ИНД-119.81-д шаардсан байгууллагын ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан байна:

- (1) бусад этгээдэд шилжүүлэх үүрэг функц; болон,
- (2) бусад этгээдээр гүйцэтгүүлэх техник үйлчилгээний цар хүрээ; болон,
- (3) үүрэг функц болон гүйцэтгэх техник үйлчилгээнд хамаарал бүхий бусад этгээдийн эрх.

119.63. Техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Өргөдөл гаргагч нь гэрчилгээний зөвшөөрлийн дагуу ашиглагдах агаарын хөлөг бүрт зориулсан техник үйлчилгээний хөтөлбөртэй байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах зүйлийг агуулсан байна:

- (1) техник үйлчилгээний хөтөлбөрт хамрагдах агаарын хөлөг бүрийн маяг, үйлдвэрийн дугаар болон бүртгэлийн дугаар; болон,
- (2) үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарь болон ИНД-91-д тодорхойлсон шаардлагуудтай ижил тэнцүү, агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс, ослын болон нэмэлт тоног төхөөрөмжүүдийн аливаа шаардлагатай үзлэг шалгалтыг багтаасан агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулагдсан журам, зааварчилгаатай байна. Үүнд үзлэг хийгдэх хэсгүүд болон эд анги нь;
 - (i) зайлшгүй шалгагдсан байх; болон,
 - (ii) хэрэв зориулалтын бус материал эсхүл эд ангийг ашиглах, эсхүл техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд агаарын хөлөгт гэмтэл, дутагдал гарч, аюултай нөхцөл байдалд хүргэх болохийг тодорхойлсон байх; болон,
- (3) энэ хэсгийн (b)(2)-т заасан техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан, хуанлийн хугацаа, нислэгийн цаг, цикл, системийн ажиллагааны тоо, эсхүл эдгээрийн нэгдлээр хийгдэх техник үйлчилгээний хуваарь; болон,
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэх тухай журам; болон,
- (5) хэрэв хөтөлбөр нь нөхцөл байдлаар хянах/ condition monitored maintenance/ техник үйлчилгээ, эсхүл бодит байдал болон ашиглалтын мониторингийн/ health and usage monitoring/ системээс авсан мэдээллийг ашиглахаар тусгагдсан бол техник үйлчилгээний чиг хандлагад дүн шинжилгээ хийх журам; болон,
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрөөр шаардсан үзлэг бүр хийгдсэн эсэхийг бататгах журам; болон,

- (7) бүртгэлийн жишээг оролцуулсан илэрсэн гэмтэл дутагдлыг бүртгэх журам; болон,
- (8) илэрсэн гэмтэл дутагдлыг засаж арилгах, эсхүл засаж залруулах арга хэмжээг хойшлуулах тухай журам; болон,
- (9) ашиглалтын зохих дадлага туршлага дээр үндэслэн үзлэгийн хоорондох үечлэлийг өөрчлөх журам; болон,
- (10) ИНД-91.623-ийн дагуу техник үйлчилгээний талаарх бүртгэл тэмдэглэлийг хадгалах журам.

119.64. Нислэгийн аюулгүй ажиллагааны бичиг баримтын тогтолцоо/ Flight safety documents system

(a) Өргөдөл гаргагч нь өөрийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцооны хэсэгт, ажилтан ажиллагсад үйл ажиллагаандаа ашиглах болон зааварчилгаа авахад зориулсан нислэгийн аюулгүй ажиллагааны бичиг баримтын тогтолцоог бүрдүүлсэн байна.

(b) Нислэгийн аюулгүй ажиллагааны бичиг баримтын тогтолцоог хөгжүүлэх нь цогц үйл ажиллагаа бөгөөд тогтолцооны бүрдэлд хамаарах бичиг баримт бүрт гарах өөрчлөлт нь нийт тогтолцоонд нөлөөлж болзошгүйг тооцож үздэг байна.

(c) Үйл ажиллагааны бичиг баримтууд нь өөр хоорондоо уялдаатай байх бөгөөд иргэний нисэхийн дүрэм, журам, агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн шаардлага, хүний хүчин зүйлийн зарчим зэрэгт нийцсэн байна. Мөн байгууллагын алба, хэлтэс хоорондын уялдаа холбоог хангаж, тэдгээрийг хэрэглэх дэс дарааллыг бататгасан байна.

(d) АТГ эзэмшигчийн бичиг баримтын тогтолцоо нь энэ дүрмийн Хавсралт Е-д заасан үндсэн хэсгүүдийг агуулсан байна.

119.65. Баримт бичиг

(a) Өргөдөл гаргагч нь нислэгийн үйл ажиллагаа, техник үйлчилгээ, аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг түгээх, хянах, нэмэлт өөрчлөлт оруулах журмыг тогтоосон байна.

(b) Өргөдөл гаргагч нь ИНД-91, ИНД-108, ИНД-121 болон ИНД-125-ийг оролцуулаад холбогдох бусад дүрмээр шаардсан бичиг баримтуудад хяналт тавих бичиг баримтын хяналтын журамтай байна.

(c) Бичиг баримтын хяналтын журам нь дараах зүйлүүдийг бататгана:

- (1) бүх бичиг баримтууд нь ашиглалтад гарахаас өмнө холбогдох эрх бүхий этгээдээр хянагдаж зөвшөөрөгдсөн байх; болон,
- (2) хүчин төгөлдөр болсон бичиг баримтууд нь шаардлагатай ажлын байр бүрт, холбогдох ажиллагсдад хэвлэмэл хувиар болон компьютерийн файлаар, эсхүл ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хүргэгдсэн байх; болон,
- (3) ашиглалтаас хасагдсан бичиг баримтуудыг ашиглаж буй ажлын байр бүрээс яаралтай хураан авсан байх; болон,
- (4) бичиг баримтад хийгдсэн өөрчлөлт шинэчлэлт нь холбогдох албан тушаалтнаар хянагдаж батлагдсан байх; болон,
- (5) бичиг баримтын хүчин төгөлдөр хувь бүрд хүчингүй болсон буюу өөрчлөлт орсон хэсгүүдийг зааж тэмдэглэсэн байх.

119.67. Боловсон хүчний бүртгэл

(а) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг бататгах бүртгэлийн журмыг тогтоосон байна:

- (1) дор заасан бүртгэлийг үнэн зөв хөтлөх:
 - (i) ажилтан бүрийн үүрэг хариуцлага болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үнэмлэх, зэрэглэл эзэмшсэн талаар; болон,
 - (ii) ИНЕГ-ын даргаас шилжигдсэн аливаа эрх, үүргийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан бүрийн талаар; болон,
 - (iii) гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон аливаа эрхийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан бүрийн талаар; болон,
- (2) бүртгэл нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна:
 - (i) энэ зүйлийн (1)-д заагдсан ажилтан бүрийн мэргэшил, дадлага туршлага, сургалтын талаар; болон,
 - (ii) энэ зүйлийн (1)(i)-д заасан үнэмлэх, зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй хугацааны талаар; болон,
 - (iii) энэ зүйлийн (1)(ii)-д заасан шилжигдсэн эрх, үүргийн талаар; болон,
 - (iv) энэ зүйлийн (1)(iii)-т заасан гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон эрхийн талаар; болон,
- (3) дараах тохиолдолд тухайн ажилтны талаарх бүртгэлийг гурван жилийн хугацаагаар хадгалах:
 - (i) үнэмлэх, зэрэглэлээр шаардсан үүрэгт ажлаа гүйцэтгэхээ болих, эсхүл

- (ii) шилжигдсэн болон олгогдсон эрхийг эдлэхээ болих.

119.69. Тоног төхөөрөмжийн хангалтын тухай бүртгэл

(a) Өргөдөл гаргагч дараах тоног төхөөрөмжийн хангалтыг бататгах бүртгэлийн журмыг тогтоосон байна:

- (1) гэрчилгээнд тодорхойлсон агаарын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашиглагддаг, нислэгийн аюулгүй ажиллагаанд онцгой нөлөөлөх хэрэгслүүдийн үзлэг, шалгалт болон тохируулгын талаарх үнэн зөв бичиглэлийн дэлгэрэнгүйг; болон,
- (2) энэ хэсгийн (1)-д заагдсан бүртгэл тэмдэглэлийг бичигдсэн өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хадгалах.

119.71. Нислэгийн зөвшөөрөл ба хяналт

(a) Өргөдөл гаргагч нь 119.51(b)(1)(i)-д заагдсан этгээдээр нислэг бүрийн эсхүл дараалсан нислэгийн эхлэл, үргэлжлэл болон төгсгөл нь хянагдаж, зөвшөөрөгдсөн гэдгийг бататгах журмыг тогтоосон байна.

119.73. Нислэгийн хяналтын үйлчилгээ

(a) Өргөдөл гаргагч нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад бүртгэгдээгүй, нислэгийн төлөвлөгөөний дагуу хийх аливаа нислэгийн үйл ажиллагааг нислэгийн хяналтын үйлчилгээгээр хангах журмыг тогтоосон байна.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь нислэг бүрийг нислэгийн хяналтын үйлчилгээгээр хангасан ба нислэгийн хяналтын үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дараах зүйлээр хангагдсан гэдгийг тус тус бататгана:

- (1) ИНД-91.307(в)-д шаардсан ил харааны нислэгийн дүрмээр хийгдэх нислэгийн төлөвлөгөөний мэдээллүүд; болон,
- (2) нислэгийн үйл ажиллагааг дуусгах урьдчилан тогтоосон хугацааны талаарх мэдээлэл; болон,
- (3) хэрэв агаарын хөлөг нь энэ зүйлийн (в)-д заасан нөхцөлөөр холбоо барих боломжгүй бүсэд нислэг үйлдэх тохиолдолд эргэж холбоо барих байршил болон холбоог дахин сэргээх хугацааг тогтоосон байх; болон,
- (4) нислэгийн хяналтын үйлчилгээнд агаарын хөлгийн даргаас мэдээлэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардагдаж болох бусад арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; болон,

(5) Хэрэв (2), (3), (4)-д заасан урьдчилан тогтоосон хугацаанд агаарын хөлгийн даргатай холбоо тогтоож чадаагүй бол дараах байгууллагуудад цаг тухайд нь шуурхай мэдэгдэх :

(i) эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах төв; эсхүл,

(ii) Даргын хүлээн зөвшөөрсөн онцгой байдлын арга хэмжээг авах боломжтой байгууллага.

(с) Дарга зөвшөөрөл олгоогүй тохиолдолд агаарын хөлөг нь энэ зүйлийн (b)(3)-т заасан нөхцөлд 30 минутаас дээш хугацаагаар холбоогүй нислэг үйлдэхийг хориглоно.

119.75. Агаарын тээвэрлэгчийн Аюулгүй байдлын хөтөлбөр

(а) Өргөдөл гаргагч нь нисэх багийн суудлаас гадна 9 буюу түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгөөр Монгол Улсын нутаг дэвсгэрт, эсхүл Монгол Улсаас гадагш зорчигч тээврийн тогтмол нислэг үйлдэхээр төлөвлөсөн бол ИНД-108-ын шаардлагыг хангасан Аюулгүй байдлын хөтөлбөртэй байна.

119.77. Үйл ажиллагааны журам тогтоох

(а) Өргөдөл гаргагч нь явуулахаар төлөвлөж буй агаарын тээврийн үйл ажиллагаандаа мөрдөх, энэ дүрэм болон бусад дүрмийн шаардлагуудыг хангасан журмыг тогтоосон байна.

119.79. Аюулгүй ажиллагааны удирдлага

(а) Арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-100.3-д заасны дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн хадгалсан байна.

119.81. Арилжааны агаарын тээвэрлэгчийн байгууллагын ерөнхий зааварт тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагч дор заасан зүйлийг багтаасан байгууллагын ерөнхий зааврыг Даргад ирүүлсэн байна:

(1) Байгууллагын ерөнхий заавар болон бусад холбогдох үйл ажиллагааны заавруудад дараах шаардлагуудыг тусгасан гэдгийг бататгасан Гүйцэтгэх захирлын гарын үсэг зурсан албан ёсны мэдэгдэл :

- (i) энэ дүрэм болон бусад холбогдох дүрмүүдийг тогтмол дагаж мөрдөж буйг бататгах арга хэрэгслийг харуулсан ба тодорхойлсон; болон,
 - (ii) зааврыг байгууллагын ажиллагсад байнга дагаж мөрдөхийг шаардсан; болон,
- (1A) ИНД-119.79-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд хамааруулан:
- (i) ИНД-100.3(b)-д шаардсан баримт бичгүүд; болон,
 - (ii) Агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулахаас бусад өргөдөл гаргагчийн хувьд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог яаж хэрэгжүүлэх талаар тодорхойлсон гүйцэтгэлийн төлөвлөгөө; болон,
- (2) энэ дүрмийн 119.51(a)(1) ба (2)-т шаардсан удирдах ажилтнуудын нэрс болон албан тушаалын нэр; болон,
- (3) энэ дүрмийн 119.51(a)(1) ба (2)-т шаардсан удирдах албан тушаалтнуудын дараах зүйлүүдийг агуулсан үүрэг, хариуцлагын талаар:
- (i) эдгээр албан тушаалтан нь хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа холбогдсон асуудлаар байгууллагын нэрийн өмнөөс Даргатай эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тухай;
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын талаар хүлээх үүрэг хариуцлага; болон,
- (4) агаарын тээврийн үйл ажиллагаанд оролцож буй ажилтнуудын ажлын байр бүрээр үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлсон товч танилцуулга; болон,
- (5) ИНД-119.51(a)(1) энэ зүйлийн (а) хэсгийн (2)-т шаардсан удирдах албан тушаалтнуудын үүрэг хариуцлагыг харуулсан бүтэц зохион байгуулалтын бүдүүвч зураглалыг энэ зүйлийн (а)-ийн (4)-т заасан ажлын байрны байршил тус бүрээр дэлгэрүүлэн үзүүлсэн байх; болон,
- (6) энэ зүйлийн (а)-ийн (4)-ийн дагуу ажлын байр бүрээр ажиллагсдын бүтэц зохион байгуулалтыг харуулсан танилцуулга; болон,
- (6A) байгууллагын хүрээнд аюулгүй ажиллагааны талаар хүлээх шууд хариуцлагын хамаарлыг тодорхойлсон мэдээлэл; болон,
- (7) үйл ажиллагааны үндсэн байршил, болон шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн төвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд; болон,
- (8) 119.55-д шаардсан хангамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд; болон,

- (9) энэ дүрмээр шаардсан журмуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд; болон,
- (10) техник үйлчилгээтэй холбоотой дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) энэ дүрмийн 119.61-д шаардсан техник үйлчилгээний журмуудын талаар; болон,
 - (ii) энэ дүрмийн 119.63-т шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн талаар; болон,
 - (iii) өргөдөл гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэх техник үйлчилгээний байгууллагын талаар; болон,
- (11) энэ дүрэм болон ИНД-121, ИНД-125, эсхүл ИНД-135-д шаардсан тохирох хөтөлбөрийн дэлгэрэнгүй; болон,
- (12) гадаад улсад үйл ажиллагаа явуулах бол тухайн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; болон,
- (13) байгууллагын ерөнхий зааварт өөрчлөлт шинэчлэлт хийх, тэдгээрийг хянах болон түгээх журмууд.

(b) Өргөдөл гаргагчийн байгууллагын ерөнхий заавар нь Даргаас хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.

В БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭЖИЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

119.101. Боловсон хүчинд тавигдах шаардлага

(a) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ /цаашид АТГ гэх/ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дараах эрх, үүрэг бүхий албантушаалтнуудыг үндсэн, гэрээгээр болон бусад хэлбэрээр ажиллуулна:

- (1) гүйцэтгэх захирлын үүрэг хүлээсэн удирдах албан тушаалтан нь:
 - (i) өргөдөл гаргагч байгууллагын зүгээс явуулж буй үйл ажиллагаа бүр нь энэ дүрэмд заасан шаардлага болон стандартуудын дагуу гүйцэтгэгдэж, санхүүжиж байгааг бататгах; болон,
 - (ii) энэ дүрэмд заасан шаардлага бүрийг байгууллага нь үйл ажиллагаандаа дагаж мөрдөж байгааг бататгах үүргийг тус тус хүлээх; болон,
- (2) бусад удирдах албан тушаалтан нь:
 - (i) байгууллагын ерөнхий зааврыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэг хүлээх; болон,

- (ii) энэ зүйлийн (b)(1)-д заасан, хамаарах үйл ажиллагааны хувьд хариуцлага хүлээх;
 - (iii) гүйцэтгэх захирлын өмнө шууд хариуцлага хүлээх; болон,
 - (3) байгууллагын ерөнхий зааварт тодорхойлогдсон үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, хянах, шалгах болон баталгаажуулахад хүрэлцэхүйц тооны гүйцэтгэх ажилтантай байна.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан удирдах албан тушаалтнууд нь:
- (1) ИНЕГ-ын дарга, өргөдөл гаргагчийн явуулах гэж буй агаарын тээврийн үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан өөрөөр тогтоогоогүй бол дараах үйл ажиллагаа тус бүрийг хариуцсан удирдах албан тушаалтантай байна:
 - (i) нислэгийн болон газрын үйлчилгээний үйл ажиллагаа оролцуулсан агаарын тээврийн үйл ажиллагааг хариуцсан;
 - (ii) нисэх багийн сургалт, болон ур чадварын үнэлгээ хариуцсан;
 - (iii) техник үйлчилгээг хянах болон хувиарт төлөвлөлт хариуцсан;
 - (iv) ИНД-119.124-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан
 - (v) ИНД-12 –ийн дагуу осол, зөрчлийн шинжлэн шалгах үйл ажиллагаа явуулах; болон,
 - (2) Удирдах албан тушаалтан нь хүлээсэн үүрэгт ажлыг гүйцэтгэхэд шаардагдах,энэ дүрмийн Хавсралт Б-д заасан мэргэшил, дадлага туршлага эзэмшисэн гэдгийг бататгасан байна.
- (c) Энэ зүйлийн (b)(1)(ii)-д заасныг үл харгалзан Өргөдөл гаргагчийн агаарын тээврийн үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан (b)(1)(i)хэсэгт заасан агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан болон нисэх багийн ур чадварын үнэлгээхариуцсан удирдах албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэгтгэж болно.

119.103. Мэргэжлийн ур чадварт тавигдах шаардлагууд

- (a) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн өргөдөл гаргагч нь дараах журмыг тогтоосон байна:
- (1) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан агаарын тээврийн үйл ажиллагааг төлөвлөх, гүйцэтгэх, баталгаажуулах, хянах, эсхүл гэрчилгээжүүлэх эрх бүхий ажилтны анхан шатны суурь мэдлэгийг дүгнэх болон тэдгээрийн мэргэжлийн ур чадварыг хадгалах, дээшлүүлэх; болон,

(2) эрх, үүргийн хүрээг тодорхойлсон бичгээр гаргасан баталгаагаар эрх бүхий ажилтнууд хангагдсан гэдгийг бататгах.

(b) Энэ зүйлийн (a)-ийн (1)-д заасан ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг шалгаж үнэлгээ өгөх, эсхүл ур чадварыг хадгалах болон дээшлүүлэх сургалт дадлагыг зохион байгуулах эрх бүхий ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагатай өргөдөл гаргагч гэрээ байгуулж болно.

(c) Энэ зүйлийн (b) хэсэгт заасны дагуу гэрээ байгуулсан тохиолдолд өргөдөл гаргагч нь байгууллагын ерөнхий заавартаа дараах мэдээллүүдийг дэлгэрэнгүй тусгасан байна:

- (1) гэрээт байгууллагад шилжүүлсэн эрх, үүрэг; болон,
- (2) гэрээт байгууллагын явуулах сургалт дадлага болон шалгалтын хүрээ; болон,
- (3) гэрээт байгууллагын сургалт, дадлага болон шалгахтай холбогдсон үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (b) хэсэгт заасны өөр нэг хувилбар болгож зохих шаардлага хангасан нислэгийн шалгагчийн зохих эрх эзэмшигчээр гүйцэтгүүлэх, Дарга хүлээн зөвшөөрсөн гадаад шалгалтын эсхүл сургалтын хөтөлбөрийг ашиглаж болно.

119.105. Хангамжид тавигдах шаардлагууд

(a) Өргөдөл гаргагч нь Дарга хүлээн зөвшөөрөхүйц дараах хангамжтай байна:

- (1) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан үйл ажиллагааг явуулах хангалттай нөхцөл бололцоотой байх; болон,
- (2) тэдгээр нь дараах зүйлийг багтаасан байна:
 - (i) албан өрөө, тасалгаатай ажлын байр, засвар үйлчилгээний цех, ангар болон техник үйлчилгээний барилга байгууламж; болон,
 - (ii) үйл ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сэлбэг материал сургалтын хэрэгслүүд болон мэдээллүүд, баримт бичиг.

(b) Өргөдөл гаргагчийн ажлын байрны хүрээлэн буй орчин нь дараах нөхцөлийг хангасныг бататгана:

- (1) ажил, үүргээ гүйцэтгэхэд тохиромжтой байх; болон,
- (2) цаг агаарын тааламжгүй аливаа нөхцөлөөс хамгаалагдсан байх.

119.107 Шалгах нислэг эсхүл туршилтууд

- (a) Гэрчилгээ эзэмшихээр, эсхүл гэрчилгээндээ нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөдөл гаргагч нь Дарга шаардсан тохиолдолд аливаа хамаарал бүхий тогтоогдсон шаардлагуудыг хангаж байгааг нотлох шалгах нислэг буюу туршилтуудыг үйлдэнэ.
- (b) шалгах нислэг буюу туршилтуудыг Даргын хүлээн зөвшөөрсөн аргачлалаар гүйцэтгэнэ.

119.109. Техник үйлчилгээний журмууд

(a) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүссэн өргөдөл гаргагч нь дараах агаарын хөлөг болон тоног төхөөрөмжийн нислэгт тэнцэх чадварын хадгалалтыг баталгаажуулах журмыг тогтоосон байна:

- (1) гэрчилгээний олгогдсон зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа агаарын хөлөг тус бүрийн; болон,
- (2) агаарын хөлөгт суурилуулсан болон бэхлэгдсэн аливаа тоног төхөөрөмж тус бүрийн.

(b) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ хүсэгч нь өөрийн агаарын хөлгийн техник үйлчилгээг бусад этгээдээр гэрээгээр гүйцэтгүүлэх бол ИНД-119.125-д шаардсан байгууллагын ерөнхий зааварт дараах дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан байна:

- (1) бусад этгээдэд шилжүүлэх үүрэг функц; болон,
- (2) бусад этгээдээр гүйцэтгүүлэх техник үйлчилгээний цар хүрээ; болон,
- (3) үүрэг функц болон гүйцэтгэх техник үйлчилгээнд хамаарал бүхий бусад этгээдийн эрх.

119.111 Техник үйлчилгээний хөтөлбөр

(a) Өргөдөл гаргагч нь гэрчилгээний зөвшөөрлийн дагуу ашиглагдах агаарын хөлөг бүрт зориулсан техник үйлчилгээний хөтөлбөртэй байна.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан техник үйлчилгээний хөтөлбөр нь дараах зүйлийг агуулсан байна:

- (1) техник үйлчилгээний хөтөлбөрт хамрагдах агаарын хөлөг бүрийн маяг, үйлдвэрийн дугаар болон бүртгэлийн дугаар; болон,

- (2) үйлдвэрлэгчийн техник үйлчилгээний хуваарь болон ИНД-91-д тодорхойлсон шаардлагуудтай ижил тэнцүү, агаарын хөлгийн их бие, хөдөлгүүр, сэнс, ослын болон нэмэлт тоног төхөөрөмжүүдийн аливаа шаардлагатай үзлэг шалгалтыг багтаасан агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулагдсан журам, зааварчилгаатай байна. Үүнд үзлэг хийгдэх хэсгүүд болон эд анги нь;
 - (i) зайлшгүй шалгагдсан байх; болон,
 - (ii) хэрэв зориулалтын бус материал эсхүл эд ангийг ашиглах, эсхүл техник үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд агаарын хөлөгт гэмтэл, дутагдал гарч, аюултай нөхцөл байдалд хүргэх болохийг тодорхойлсон байх; болон,
- (3) энэ хэсгийн (b)(2)-т заасан техник үйлчилгээг гүйцэтгэхэд зориулсан, хуанлийн хугацаа, нислэгийн цаг, цикл, системийн ажиллагааны тоо, эсхүл эдгээрийн нэгдлээр хийгдэх техник үйлчилгээний хуваарь; болон,
- (4) агаарын хөлгийг техник үйлчилгээний хөтөлбөрт нэмэх тухай журам; болон,
- (5) хэрэв хөтөлбөр нь нөхцөл байдлаар хянах/ condition monitored maintenance/ техник үйлчилгээ, эсхүл бодит байдал болон ашиглалтын мониторингийн/ health and usage monitoring/ системээс авсан мэдээллийг ашиглахаар тусгагдсан бол техник үйлчилгээний чиг хандлагад дүн шинжилгээ хийх журам; болон,
- (6) техник үйлчилгээний хөтөлбөрөөр шаардсан үзлэг бүр хийгдсэн эсэхийг бататгах журам; болон,
- (7) бүртгэлийн жишээг оролцуулсан илэрсэн гэмтэл дутагдлыг бүртгэх журам; болон,
- (8) илэрсэн гэмтэл дутагдлыг засаж арилгах, эсхүл засаж залруулах арга хэмжээг хойшлуулах тухай журам; болон,
- (9) ашиглалтын зохих дадлага туршлага дээр үндэслэн үзлэгийн хоорондох үечлэлийг өөрчлөх журам; болон,
- (10) ИНД-91.623-ийн дагуу техник үйлчилгээний талаарх бүртгэл тэмдэглэлийг хадгалах журам.

119.113. Баримт бичиг

- (a) ИНД-119.124(с)-д заасны дагуу удирдлагын тогтолцоо шаардлагатай ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн өргөдөл гаргагч нь нислэгийн үйл

ажиллагаа, техник үйлчилгээ, аюулгүй ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг түгээх, хянах, нэмэлт өөрчлөлт оруулах журмыг тогтоосон байна.

(b) Өргөдөл гаргагч нь ИНД-91 болон ИНД-135-ийг оролцуулаад холбогдох бусад дүрмээр шаардсан бичиг баримтуудад хяналт тавих бичиг баримтын хяналтын журамтай байна.

(c) Бичиг баримтын хяналтын журам нь дараах зүйлүүдийг бататгана:

- (1) бүх бичиг баримтууд нь ашиглалтад гарахаас өмнө холбогдох эрх бүхий этгээдээр хянагдаж зөвшөөрөгдсөн байх; болон,
- (2) хүчин төгөлдөр болсон бичиг баримтууд нь шаардлагатай ажлын байр бүрт, холбогдох ажиллагсдад хэвлэмэл хувиар болон компьютерийн файлаар, эсхүл ИНЕГ-ын дарга хүлээн зөвшөөрөхүйц бусад хэлбэрээр хүргэгдсэн байх; болон,
- (3) ашиглалтаас хасагдсан бичиг баримтуудыг ашиглаж буй ажлын байр бүрээс яаралтай хураан авсан байх; болон,
- (4) бичиг баримтад хийгдсэн өөрчлөлт шинэчлэлт нь холбогдох албан тушаалтнаар хянагдаж батлагдсан байх; болон,
- (5) бичиг баримтын хүчин төгөлдөр хувь бүрд хүчингүй болсон буюу өөрчлөлт орсон хэсгүүдийг зааж тэмдэглэсэн байх.

119.67. Боловсон хүчний бүртгэл

(a) Өргөдөл гаргагч нь дараах зүйлийг бататгах бүртгэлийн журмыг тогтоосон байна:

- (1) дор заасан бүртгэлийг үнэн зөв хөтлөх:
 - (i) ажилтан бүрийн үүрэг хариуцлага болон ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах үнэмлэх, зэрэглэл эзэмшсэн талаар; болон,
 - (ii) ИНЕГ-ын даргаас шилжигдсэн аливаа эрх, үүргийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан бүрийн талаар; болон,
 - (iii) гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон аливаа эрхийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан бүрийн талаар; болон,
- (2) бүртгэл нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна:
 - (i) энэ зүйлийн (1)-д заагдсан ажилтан бүрийн мэргэшил, дадлага туршлага, сургалтын талаар; болон,
 - (ii) энэ зүйлийн (1)(i)-д заасан үнэмлэх, зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй хугацааны талаар; болон,

- (iii) энэ зүйлийн (1)(ii)-д заасан шилжигдсэн эрх, үүргийн талаар; болон,
- (iv) энэ зүйлийн (1)(iii)-т заасан гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон эрхийн талаар; болон,
- (3) дараах тохиолдолд тухайн ажилтны талаарх бүртгэлийг нэг жилийн хугацаагаар хадгалах:
 - (i) үнэмлэх, зэрэглэлээр шаардсан үүрэгт ажлаа гүйцэтгэхээ болих, эсхүл
 - (ii) шилжигдсэн болон олгогдсон эрхийг эдлэхээ болих

119.117. Тоног төхөөрөмжийн хангалтын тухай бүртгэл

(a) Өргөдөл гаргагч дараах тоног төхөөрөмжийн хангалтыг бататгах бүртгэлийн журмыг тогтоосон байна:

- (1) гэрчилгээнд тодорхойлсон агаарын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашиглагддаг, нислэгийн аюулгүй ажиллагаанд онцгой нөлөөлөх хэрэгслүүдийн үзлэг, шалгалт болон тохируулгын талаарх үнэн зөв бичиглэлийн дэлгэрэнгүйг; болон,
- (2) энэ хэсгийн (1)-д заагдсан бүртгэл тэмдэглэлийг бичигдсэн өдрөөс эхлэн хоёр жилийн хугацаанд хадгалах.

119.119. Нислэгийн зөвшөөрөл ба хяналт

(a) Өргөдөл гаргагч нь 119.101(b)(1)(i)-д заагдсан этгээдээр нислэг бүрийн эсхүл дараалсан нислэгийн эхлэл, үргэлжлэл болон төгсгөл нь хянагдаж, зөвшөөрөгдсөн гэдгийг бататгах журмыг тогтоосон байна.

119.121. Нислэгийн хяналтын үйлчилгээ

(a) Өргөдөл гаргагч нь Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагад бүртгэгдээгүй, нислэгийн төлөвлөгөөний дагуу хийх аливаа нислэгийн үйл ажиллагааг нислэгийн хяналтын үйлчилгээгээр хангах журмыг тогтоосон байна.

(b) Энэ зүйлийн (a)-д шаардсан журам нь нислэг бүрийг нислэгийн хяналтын үйлчилгээгээр хангасан ба нислэгийн хяналтын үйлчилгээ үзүүлж буй этгээд нь дараах зүйлээр хангагдсан гэдгийг тус тус бататгана:

- (1) ИНД-91.307(c)-д шаардсан ил харааны нислэгийн дүрмээр хийгдэх нислэгийн төлөвлөгөөний мэдээллүүд; болон,
- (2) нислэгийн үйл ажиллагааг дуусгах урьдчилан тогтоосон хугацааны талаарх мэдээлэл; болон,

- (3) хэрэв агаарын хөлөг нь энэ зүйлийн (в)-д заасан нөхцөлөөр холбоо барих боломжгүй бүсэд нислэг үйлдэх тохиолдолд эргэж холбоо барих байршил болон холбоог дахин сэргээх хугацааг тогтоосон байх; болон,
- (4) нислэгийн хяналтын үйлчилгээнд агаарын хөлгийн даргаас мэдээлэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангахад шаардагдаж болох бусад арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; болон,
- (5) Хэрэв (2), (3), (4)-д заасан урьдчилан тогтоосон хугацаанд агаарын хөлгийн даргатай холбоо тогтоож чадаагүй бол дараах байгууллагуудад цаг тухайд нь шуурхай мэдэгдэх :
 - (i) эрэн хайх, авран туслах мэдээлэл зохицуулах төв; эсхүл,
 - (ii) Даргын хүлээн зөвшөөрсөн онцгой байдлын арга хэмжээг авах боломжтой байгууллага.

(с) агаарын хөлөг нь энэ зүйлийн (b)(3)-т заасны дагуу дараах хугацаанд холбоогүй байж болно:

- (1) Хэрэв агаарын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа бол 30 минутаас дээшгүй хугацаанд; эсхүл,
- (2) Хэрэв арилжааны тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа бол (а)-д заасан журмын дагуу нислэг үйлдэхээс өмнө тогтоосон дурын хугацаанд.

119.123. Үйл ажиллагааны журам тогтоох

(а) Өргөдөл гаргагч нь явуулахаар төлөвлөж буй агаарын тээврийн үйл ажиллагаандаа мөрдөх, энэ дүрэм болон бусад дүрмийн шаардлагуудыг хангасан журмыг тогтоосон байна.

119.124. Аюулгүй ажиллагааны удирдлага

(а) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-100.3-д заасны дагуу аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн хадгалсан байна.

119.125. Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн байгууллагын ерөнхий зааварт тавигдах шаардлага

(а) Өргөдөл гаргагч дор заасан зүйлийг багтаасан байгууллагын ерөнхий зааврыг Даргад ирүүлсэн байна:

- (1) Байгууллагын ерөнхий заавар болон бусад холбогдох үйл ажиллагааны заавруудад дараах шаардлагуудыг тусгасан гэдгийг бататгасан Гүйцэтгэх захирлын гарын үсэг зурсан албан ёсны мэдэгдэл :
 - (i) энэ дүрэм болон бусад холбогдох дүрмүүдийг тогтмол дагаж мөрдөж буйг бататгах арга хэрэгслийг харуулсан ба тодорхойлсон; болон,
 - (ii) зааврыг байгууллагын ажиллагсад байнга дагаж мөрдөхийг шаардсан; болон,
- (1A) ИНД-119.124-д шаардсан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоонд хамааруулан:
 - (i) ИНД-100.3(b)-д шаардсан баримт бичгүүд; болон,
 - (ii) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгуулахаас бусад өргөдөл гаргагчийн хувьд аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог яаж хэрэгжүүлэх талаар тодорхойлсон гүйцэтгэлийн төлөвлөгөө; болон,
- (2) энэ дүрмийн 119.101(a)(1) ба (2)-т шаардсан удирдах ажилтнуудын нэрс болон албан тушаалын нэр; болон,
- (3) энэ дүрмийн 119.101(a)(1) ба (2)-т шаардсан удирдах албан тушаалтнуудын дараах зүйлүүдийг агуулсан үүрэг, хариуцлагын талаар:
 - (i) эдгээр албан тушаалтан нь хүлээсэн үүрэг хариуцлагатайгаа холбогдсон асуудлаар байгууллагын нэрийн өмнөөс Даргатай эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тухай;
 - (ii) аюулгүй ажиллагааны удирдлагын талаар хүлээх үүрэг хариуцлага; болон,
- (4) шаардлагатай бол ИНД-119.101(a)(1) болон (a)(2)-т шаардсан удирдах албан тушаалтнуудын үүрэг хариуцлагын хамаарлыг харуулсан бүтэц зохион байгуулалтын бүдүүвч зураглал; болон,
- (4A) байгууллагын хүрээнд аюулгүй ажиллагааны талаар хүлээх хариуцлагыг тодорхойлсон мэдээлэл; болон,
- (5) үйл ажиллагааны үндсэн байршил болон техник үйлчилгээний үндсэн төвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд; болон,
- (6) энэ дүрмээр шаардсан журмуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллүүд; болон,
- (7) техник үйлчилгээтэй холбоотой дараах дэлгэрэнгүй мэдээлэл:
 - (i) энэ дүрмийн 119.109-д шаардсан техник үйлчилгээний журмуудын талаар; болон,

- (ii) энэ дүрмийн 119.111-д шаардсан техник үйлчилгээний хөтөлбөрийн талаар; болон,
 - (iii) өргөдөл гаргагчийн агаарын хөлөгт техник үйлчилгээг гүйцэтгэх техник үйлчилгээний байгууллагын талаар; болон,
 - (8) энэ дүрэм болон ИНД-135-д шаардсан тохирох хөтөлбөрийн дэлгэрэнгүй; болон,
 - (9) гадаад улсад үйл ажиллагаа явуулах бол тухайн улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх журмын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл; болон,
 - (10) байгууллагын ерөнхий зааварт өөрчлөлт шинэчлэлт хийх, тэдгээрийг хянах болон түгээх журмууд.
- (b) Өргөдөл гаргагчийн байгууллагын ерөнхий заавар нь Даргаас хүлээн зөвшөөрөгдсөн байх ёстой.

Г БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШААРДЛАГА

119.151. Нийцлийн хадгалалт

- (a) Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн 119.15-д заасан үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөнө.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь дор заасан шаардлагуудыг хангасан байна:
- (1) энэ дүрмийн Бүлэг Б, эсхүл Бүлэг В-ийн холбогдох шаардлагуудыг дагаж мөрдөх ба стандартуудыг тогтмол хангаж үйл ажиллагаагаа явуулна;
 - (2) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан хөтөлбөр болон журам бүрийг дагаж мөрдөнө;
 - (3) байгууллагын ерөнхий зааварт тусгагдсан үйл ажиллагааны байршил бүрт дараах зүйлсийг байрлуулсан байна:
 - (i) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны тодорхойлолтын хэвлэмэл нэг хувийг;
 - (ii) байгууллагын ерөнхий зааврын хамаарах хэсгийг хэвлэмэл болон электрон, эсхүл ИНЕГ-ын даргын зөвшөөрсөн бусад хэлбэрээр.

119.153. Нислэгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- (a) арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлөгт дараах холбогдох шаардлагыг дагаж мөрдөнө:

- (1) нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 30-аас дээш зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410 кг-аас дээш онгоцны хувьд ИНД-121-ийн шаардлагуудыг; эсхүл,
- (2) нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 10-аас 30 хүртэлх зорчигчийн суудалтай, эсхүл төлбөрт ачааллын хэмжээ нь 3410 кг буюу түүнээс доош болон Хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг-аас дээш онгоцны хувьд ИНД-125-ийн шаардлагуудыг; эсхүл,
- (3) нисэх багийн гишүүдийн суудлаас гадна 9 буюу түүнээс цөөн тооны зорчигчийн суудалтай, болон Хөөрөлтийн гэрчилгээжсэн дээд жин нь 5700 кг-аас буюу түүнээс доош онгоц эсхүл нисдэг тэрэгний хувьд энэ зүйлийн (б)-д заасныг харгалзан ИНД-135-ын шаардлагуудыг.

(b) ГХХНД/SEIFR ганц хөдөлгүүртийн-хэрэглэлийн нислэгийн дүрмээр зорчигч тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь ИНД-125-ийн шаардлагуудыг дагаж мөрдөнө.

(c) агаарын тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд ИНД-135-ийн шаардлагуудыг дагаж мөрдөнө.

119.155. Нисэх багийн мэргэшил

(a) Гэрчилгээ эзэмшигч нь ИНД-61-ийн дагуу зохих мэргэжлийн үнэмлэх, зэрэглэлгүй, болон тухайн нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх эрхгүй аливаа этгээдийг агаарын тээврийн үйл ажиллагаанд нисэх багийн гишүүнээр оролцуулахыг хориглоно.

(b) Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна нислэгийн үйл ажиллагааг гүйцэтгэх зөвшөөрөл олгогдсон аливаа этгээд нь энэ зүйлийн (a)-д шаардсаны дагуу зохих мэргэжлийн үнэмлэх болон эрүүл мэндийн хүчин төгөлдөр гэрчилгээтэй байна.

119.157. Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг түрээслэх, хөлслөх болон захиалгат нислэг үйлдэх

(a) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг нисэх багийн гишүүдтэй, эсхүл гишүүдгүй өөр агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчээс түрээслэх, хөлслөх, эсхүл захиалж нислэг үйлдэх тохиолдолд агаарын хөлгийг ашиглахын өмнө гэрчилгээ эзэмшигчтэй аль гэрчилгээний дагуу нислэг үйлдэхийг тодорхой тогтоосон байх бөгөөд энэ тухай агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын хөлгийг нисэх багийн гишүүдтэй, эсхүл гишүүдгүйгээр агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшидэггүй этгээдээс түрээслэх,

хөлслөх, эсхүл захиалж нислэг үйлдэх тохиолдолд гэрчилгээ эзэмшигч өөрийн агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний дагуу нислэг үйлдэнэ.

(с) Гэрчилгээ эзэмшигч бүр захиалгат болон түрээсээр, эсхүл хөлсөөр хийгдсэн нислэгийн гэрээний хувийг гэрээний дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1 жилээс доошгүй хугацаагаар хадгална.

(d) Агаарын хөлгийг түрээслэх, хөлслөх, эсхүл захиалж нислэг хийх хэлэлцээрийг амаар хийсэн нөхцөлд гэрчилгээ эзэмшигч нь хэлэлцээрийн нөхцөлүүдийг тодорхой тусгасан меморандум байгуулах бөгөөд түүнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлтийг тухайн хэлэлцээрийн дагуу сүүлчийн нислэг үйлдсэн өдрөөс хойш 1 жилээс багагүй хугацаагаар хадгална.

119.159. Монгол Улсад бүртгэлгүй агаарын хөлгийг ашиглах

(а) Гэрчилгээ эзэмшигч нь Монгол Улсад бүртгэлгүй агаарын хөлгөөр захиалгат нислэг үйлдэх, түрээслэх, эсхүл бусад гэрээ хэлэлцээрийн дагуу ашиглах тохиолдолд ИНЕГ-ын дарга хугацааг багаар тогтоогоогүй бол үйл ажиллагааг гүйцэтгэж эхлэхээс 30-аас доошгүй хоногийн өмнө түрээсийн болон захиалгат нислэгийн, эсхүл бусад гэрээ хэлэлцээрийн үндсэн нөхцөлүүдийн талаар ИНЕГ-ын даргад мэдэгдэх ба мэдэгдэлд дараах зүйлийг багтаасан байна:

- (1) агаарын хөлгийг нийлүүлэгч нь Чикагогийн конвенцийн хэлэлцэн тохирогч аль нэг гишүүн улсаас агаарын тээвэр эрхлэх зөвшөөрөлтэй эсэх;
- (2) гэрээ хэлэлцээр байгуулагч талуудын нэр, хаяг;
- (3) гэрээний хүчин төгөлдөр хугацаа;
- (4) гэрээнд тусгагдсан агаарын хөлгийн маяг, харъяалал, бүртгэлийн дугаар.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь Монгол Улсад бүртгэлгүй агаарын хөлгийг агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаас өмнө ИНЕГ-ын даргаас зөвшөөрөл авсан байна.

119.161. Хууль ёсны нэр болон бизнесийн нэр

(а) Гэрчилгээ эзэмшигч нь агаарын тээврийн гэрчилгээнд бичигдсэн хууль ёсны худалдааны эсхүл бизнесийн нэрийн дор агаарын тээврийн үйл ажиллагаагаа явуулна.

(b) Гэрчилгээ эзэмшигчийн худалдааны эсхүл бизнесийн нэрийг бүх зорчигчдод агаарын хөлөгт орохоос өмнө тодорхой, танигдахаар харагдах байдлаар байрлуулаагүй тохиолдолд агаарын тээврийн үйл ажиллагаа явуулахгүй.

(с) Гэрчилгээ эзэмшигч нь аливаа агаарын тээврийн зар сурталчилгааг явуулахдаа гэрчилгээнд бичигдсэн хууль ёсны нэрийг тодорхой гаргана.

119.163. Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигчид тавигдах хязгаарлалтууд

(d) Ерөнхий зориулалтын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь арилжааны агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний хүрээнд ИНД-121, эсхүл ИНД-125-ийн дагуу агаарын тээврийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

119.165. Гэрчилгээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орох

(a) Гэрчилгээ эзэмшигч нь:

- (1) байгууллагын ерөнхий зааварт өөрчлөлт орсон ч байгууллагын үндсэн чиг үүрэг болон тодорхойлолтууд хүчинтэй хэвээр үлдэнэ гэдгийг бататгана; болон,
- (2) байгууллагын ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлтүүд нь энэ дүрэм, бусад холбогдох дүрмүүдийн шаардлагад нийцэж буйг болон зааварт нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийгдсэн болохыг бататгана; болон,
- (3) байгууллагын ерөнхий зааварт нэмэлт өөрчлөлт оруулсан даруйдаа уг нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргад аль болох дадсанаараа хурдан хүргүүлнэ;
- (4) Дарга аюулгүй ажиллагааг хангахад шаардлагатай гэж үзсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг зааварт оруулна.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах зүйлд Даргаас урьдчилан зөвшөөрөл авч зохих өөрчлөлтийг хийнэ:

- (1) гүйцэтгэх захирлыг өөрчлөх;
- (2) бусад удирдах албан тушаалтныг өөрчлөх;
- (3) ИНД-119.81(а)(7), эсхүл ИНД-119.125(а)(5)-д заасан гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах зохих байршил өөрчлөгдөх;
- (4) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагааны цар хүрээ өөрчлөгдөх;
- (5) Хэрэв материаллаг өөрчлөлт бол аюулгүй ажиллагааны тогтолцоо;
- (6) [хүчингүй]
- (7) техник үйлчилгээний хөтөлбөрийг өөрчлөх;

- (8) техник үйлчилгээг гүйцэтгэдэг, эсхүл сургалтын гэрээт байгууллага өөрчлөгдөх;
- (9) нислэгийн болон ажлын байрны үүрэг хариуцлагын зураглалыг өөрчлөх;
- (10) шаардлагатай тохиолдолд, аюулгүй байдлын хөтөлбөрийг өөрчлөх.

(c) [хүчингүй]

(d) Энэ зүйлийн (b) хэсэгт заагдсан аль нэг өөрчлөлтийг хийх үед болон хийсний дараа гэрчилгээ эзэмшигчийн явуулах үйл ажиллагааны нөхцөлүүдийг ИНЕГ-ын дарга тодорхойлж өгч болно.

(e) Энэ зүйлийн (d)-ийн дагуу тодорхойлсон аливаа нөхцөлүүдийг гэрчилгээ эзэмшигч нь дагаж мөрдөнө.

(f) Энэ зүйлийн (b) хэсэгт заасан аливаа өөрчлөлтийг хийснээр гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол гэрчилгээ эзэмшигч нь ИНЕГ-ын даргад гэрчилгээг аль болох дадсанаараа хурдан ирүүлнэ.

(g) [хүчингүй]

119.167. Техник үйлчилгээний хөтөлбөрийг өөрчлөх

(a) Гэрчилгээ эзэмшигч нь Даргаас агаарын хөлгийн НТЧ-ын хадгалалтыг хангахад шаардлагатай гэж үзсэн аливаа өөрчлөлтийг техник үйлчилгээний хөтөлбөртөө оруулна

БҮЛЭГ Д ШИЛЖИЛТИЙН НӨХЦӨЛ

119.201 ИНД-121 эсхүл ИНД-125-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны агаарын тээвэрлэгчийн шилжилтийн нөхцөл

(a) Дүрмийн энэ заалт нь дараах агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчид хамаарна:

- (1) ИНД-121.1 эсхүл ИНД-125.1-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа;
- (2) ИНД-121 эсхүл ИНД-125-ийн дагуу үйл ажиллагаа явуулахаар өргөдөл гаргагч.

(b) Дүрмийн энэ заалтад хамаарах байгууллагад 2018 оны 02 сарын 01-нээс өмнө:

- (1) Дараах дүрмийн дараах заалтуудыг дагаж мөрдөхийг шаардахгүй:
 - (i) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтны оронд дотоод чанар

баталгаажуулалт хариуцсан удирдах албан тушаалтантай бол ИНД-119.51(b)(1)(iv) заалтыг:

(ii) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн хадгалах шаардлагын оронд ИНД-19.205 заасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоотой бол ИНД-119.79 заалтыг:

(iii) ИНД 119.81(a)(1A):

(iv) ИНД 119.81(a)(3)(ii):

(v) ИНД 119.81(a)(6A); гэхдээ

(2) дараах зүйлүүдийг багтаасан хэрэгжүүлэх төлөвлөгөөг САА маягтын хамт 2016 оны 09 сарын 30-наас өмнө Даргад ирүүлнэ:

(i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр төлөвлөсөн огноо.

(ii) ИНД-119.79-д заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тухайн байгууллага хэрхэн хэрэгжүүлэх тухай ерөнхий төлөвлөгөө.

(c) Шаардлага хангасан тохиолдолд Дарга:

(1) Тухайн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батална.

(2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтоож өгнө.

(d) тухайн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог Дарга баталсан огноог тухайн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн огноо гэж ойлгоно

(e) ИНД-119.201(c)(2)-д заасан огноог тогтоож өгөхдөө Дарга дараах зүйлүүдийг харгалзан үзнэ:

(1) Тухайн байгууллагын боломж:

(2) Тухайн байгууллагын хүрээ:

(3) Тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл:

(4) Аливаа гэрчилгээний хүчинтэй хугацаа:

(5) Тухайн байгууллага эсхүл ИНЕГ эсхүл хоёуланд нь нөлөөлөх аливаа нөөц бололцоо эсхүл төлөвлөлт:

(6) Хэрэгжүүлэх огноо 2018 оны 02 сарын 01-нээс сүүлд байж болохгүй.

(f) Хэрэв өргөдөл гаргагч нь агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч бол гэрчилгээжүүлэх өргөдлөө ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөний хамт гаргана.

(g) дүрмийн энэ заалт 2018 оны 02 сарын 01-нд хүчингүй болно.

119.203 ИНД-135-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн шилжилтийн нөхцөл

(a) Дүрмийн энэ заалт нь дараах агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчид хамаарна:

- (1) ИНД-135.1-д заасны дагуу аливаа үйл ажиллагаа явуулж байгаа эсхүл ИНД-125.1-ийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч:
- (2) ИНД-135.1-ийн дагуу заасны дагуу аливаа үйл ажиллагаа явуулахаар өргөдөл гаргагч.

(b) Дүрмийн энэ заалтад хамаарах байгууллагад 2021 оны 02 сарын 01-нээс өмнө:

- (1) Дараах дүрмийн дараах заалтуудыг дагаж мөрдөхийг шаардахгүй:
 - (i) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах албан тушаалтантай бол ИНД-119.51(b)(1)(iv) заалтыг:
 - (ii) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн хадгалах шаардлагын оронд ИНД-19.205 заасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоотой бол ИНД-119.79 заалтыг:
 - (iii) ИНД 119.81(a)(1A):
 - (iv) ИНД 119.81(a)(3)(ii):
 - (v) ИНД 119.81(a)(6A); гэхдээ
- (2) дараах зүйлүүдийг багтаасан хэрэгжүүлэх төлөвлөгөөг САА маягтын хамт 2018 оны 09 сарын 30-наас өмнө Даргад ирүүлнэ:
 - (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр төлөвлөсөн огноо
 - (ii) ИНД-119.79-д заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тухайн байгууллага хэрхэн хэрэгжүүлэх тухай ерөнхий төлөвлөгөө

(с) Шаардлага хангасан тохиолдолд Дарга:

- (1) Тухайн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батална
- (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтоож өгнө

(d) Дарга тухайн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог баталсан огноог аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн огноо гэж ойлгоно

(е) ИНД-119.203(с)(2)-д заасан огноог тогтоож өгөхдөө Дарга дараах зүйлүүдийг харгалзан үзнэ:

- (1) Тухайн байгууллагын боломж:
- (2) Тухайн байгууллагын хүрээ:
- (3) Тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл:
- (4) Аливаа гэрчилгээний хүчинтэй хугацаа:
- (5) Тухайн байгууллага эсхүл ИНЕГ эсхүл хоёуланд нь нөлөөлөх аливаа нөөц бололцоо эсхүл төлөвлөлт:
- (6) Хэрэгжүүлэх огноо 2018 оны 02 сарын 01-нээс сүүлд байж болохгүй.

(f) Хэрэв өргөдөл гаргагч нь агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч бол гэрчилгээжүүлэх өргөдлөө ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөний хамт гаргана.

(g) дүрмийн энэ заалт 2021 оны 02 сарын 01 хүртэл хүчинтэй.

119.205 агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт

(a) байгууллага нь энэ дүрэмд заасан журмуудад нийцсэн болон дагаж мөрдөж байгааг бататгасан ИНД-119.201(b)(1)(ii) болон ИНД-119.203(b)(1)(ii)-д шаардсан дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгосон байна

(b) Чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоо нь дараах зүйлийг агуулсан байна:

- (1) ИНД-12-ийн дагуу шинжлэн шалгах үйл ажиллагааны журмыг багтаасан чанарын удирдлагын тогтолцооны бодлого болон бодлогын журам; болон,
- (2) тогтолцооны хүрээнд оршиж буй асуудлыг илрүүлэх, эсхүл асуудал үүсгэж болзошгүй шалтгааныг тогтоох, ажиллагсдын болон үйлчлүүлэгчдийн мэдээлэл, зөрчил дутагдлын тухай илтгэл зэргийг багтаасан “Чанарын үзүүлэлтүүдийг бататгах журам” ; болон,

- (3) тогтолцооны хүрээнд илэрсэн аливаа асуудлыг засаж залруулах ажиллагааг бататгах “Залруулах арга хэмжээний журам” ; болон,
 - (4) тогтолцооны хүрээнд тогтоогдсон, асуудал үүсгэж болзошгүй шалтгааныг давтагдахаас сэргийлсэн “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам”; болон,
 - (5) өргөдөл гаргагчийн байгууллагын ерөнхий зааварт тодорхойлогдсон журмууд болон аюулгүй ажиллагааны бодлогод тавигдсан зорилтуудын биелэлтийн нийцлийг хянах “Дотоод аудитын хөтөлбөр” ; болон,
 - (6) энэ дүрмийн шаардлагуудыг хангасан, чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцооны үр нөлөө, цаашдын оновчтой байдлыг бататгах, статистикийн дүн шинжилгээг ашиглах аргачлалыг багтаасан “Удирдлага хяналтын журам”.
- (с) “Чанарын удирдлагын тогтолцооны бодлогын журам”-д тусгагдсан чанарын бодлого нь байгууллагын бүх түвшинд ойлгомжтой бөгөөд тогтвортой, хэрэгжсэн гэдгийг тус журмаар бататгана.
- (d) “Залруулах арга хэмжээний журам”-д дараах үйл ажиллагааг дэлгэрэнгүй заасан байна:
- (1) оршиж буй асуудлыг хэрхэн засаж залруулахыг; болон,
 - (2) засаж залруулах үүднээс авсан арга хэмжээ нь үр дүнтэй эсэхийг эргэж нягтлан үзэх талаар.
- (е) “Урьдчилан сэргийлэх арга хэмжээний журам”-д дараах үйл ажиллагааг дэлгэрэнгүй заасан байна:
- (1) гарч болзошгүй асуудлыг хэрхэн засаж залруулах талаар; болон,
 - (2) урьдчилан сэргийлэх үүднээс авсан арга хэмжээ нь үр дүнтэй эсэхийг эргэж нягтлан үзэх талаар; болон,
 - (3) урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнгээс хамаарч энэ дүрмээр шаардсан аливаа журамд нэмэлт өөрчлөлт оруулах талаар;
- (f) “Чанарын дотоод аудитын хөтөлбөр”-т дараах үйл ажиллагааг дэлгэрэнгүй заасан байна:
- (1) аудит хийгдэх үйл ажиллагааны шинж чанарыг тооцон үзэж, аудитыг явуулах байршил болон үечлэлийн давтамжийг тогтоох талаар; болон,
 - (2) аудитыг, шалгагдаж байгаа үйл ажиллагаанд шууд хариуцлага хүлээхгүй, тусгайлан бэлтгэгдсэн этгээд гүйцэтгэх тухай; болон,

- (3) аудитын үр дүнгийн тайланг байгууллагын дотоод аудит хариуцсан удирдах албан тушаалтанд болон шалгагдсан үйл ажиллагаанд хариуцлага хүлээсэн этгээдэд хүргүүлсэн байх талаар; болон,
- (4) аудит хийгдсэн үйл ажиллагааг хариуцсан этгээдийн сүүлийн аудитаас хойш засаж залруулсан болон урьдчилан сэргийлэх үүднээс авсан арга хэмжээний үр дүнг дүгнэсэн байх талаар; болон,
- (5) аудитын явцад дутагдал илэрсэн тохиолдолд, тухайн аудит хийгдэж буй үйл ажиллагаанд хариуцлага хүлээсэн этгээдэд засаж залруулах, эсхүл урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг шаардах талаар; болон,
- (6) эргэж нягтлан шалгах аудитаар урьдчилан сэргийлэх, эсхүл засаж залруулах үүднээс авсан аливаа арга хэмжээний үр дүнг бататгах тухай.

(g) “Удирдлагын хяналтын журам”-д дараах зүйлийг тусгасан байна:

- (1) чанарын баталгаажуулалтын тогтолцооны цаашдын үр дүнтэй байдлыг тооцох үүднээс тухайн чанарын тогтолцооны удирдлага, зохион байгуулалт болон үйл ажиллагаанд хийгдэх удирдлагын хяналт шалгалтын давтамжийг тогтоосон байх; болон,
- (2) чанарын дотоод баталгаажуулалтын тогтолцоог шалгах эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон байх; болон,
- (3) хяналт шалгалтын үр дүнг бататгах үүднээс шалгалтын тайлан бичигдэж, үнэлэлт дүгнэлт өгөгдсөн байх.

(h) Чанарын дотоод *баталгаажуулалт* хариуцсан албан тушаалтан нь аюулгүй ажиллагаанд хамааралтай аливаа асуудлаар байгууллагын гүйцэтгэх захиралтай шууд харьцана.

(i) Дүрмийн энэ заалт 2021 оны 02 сарын 01 хүртэл хүчинтэй.

119.207 Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн дотоод чанар баталгаажуулалтын шилжилт

(a) Дүрмийн энэ заалт нь дараах агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчид хамаарна:

- (1) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч:
- (2) Ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа явуулахаар өргөдөл гаргагч.

(b) Дүрмийн энэ заалтад хамаарах байгууллагад 2021 оны 02 сарын 01-нээс өмнө:

- (1) Дараах дүрмийн дараах заалтуудыг дагаж мөрдөхийг шаардахгүй:
 - (i) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах албан тушаалтантай бол ИНД-119.101(b)(1)(iv) заалтыг:
 - (ii) Хэрэв тухайн байгууллага аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэн хадгалах шаардлагын оронд ИНД-19.209 заасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоотой бол ИНД-119.124 заалтыг:
 - (iii) ИНД 119.125(a)(1A):
 - (iv) ИНД 119.125(a)(3)(ii):
 - (v) ИНД 119.125(a)(4A); гэхдээ
- (2) дараах зүйлүүдийг багтаасан хэрэгжүүлэх төлөвлөгөөг САА маягтын хамт 2018 оны 09 сарын 30-наас өмнө Даргад ирүүлнэ:
 - (i) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэхээр төлөвлөсөн огноо
 - (ii) ИНД-119.124-д заасан аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог тухайн байгууллага хэрхэн хэрэгжүүлэх тухай ерөнхий төлөвлөгөө.
- (c) Шаардлага хангасан тохиолдолд Дарга:
 - (1) Тухайн байгууллагын хэрэгжүүлэх төлөвлөгөөг батална.
 - (2) аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх огноог тогтоож өгнө.
- (d) Дарга тухайн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог баталсан огноог аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоог хэрэгжүүлсэн огноо гэж ойлгоно.
- (e) ИНД-119.207(c)(2)-д заасан огноог тогтоож өгөхдөө Дарга дараах зүйлүүдийг харгалзан үзнэ:
 - (1) Тухайн байгууллагын боломж:
 - (2) Тухайн байгууллагын хүрээ:
 - (3) Тухайн байгууллагын үйл ажиллагаанд оршиж байгаа эрсдэл:
 - (4) Аливаа гэрчилгээний хүчинтэй хугацаа:
 - (5) Тухайн байгууллага эсхүл ИНЕГ эсхүл хоёуланд нь нөлөөлөх аливаа нөөц бололцоо эсхүл төлөвлөлт:

(6) Хэрэгжүүлэх огноо 2021 оны 02 сарын 01-нээс сүүлд байж болохгүй.

(f) Хэрэв өргөдөл гаргагч нь агаарын тээвэрлэгчийн нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийнгэрчилгээ эзэмшигч бол гэрчилгээжүүлэх өргөдлөө ажиллагааны удирдлагын тогтолцооны хэрэгжилтийн төлөвлөгөөний хамт гаргана.

(g) дүрмийн энэ заалт 2021 оны 02 сарын 01 хүртэл хүчинтэй.

119.209 ерөнхий зориулалтын нислэгийн үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээ эзэмшигч болон өргөдөл гаргагчийн байгууллагын удирдлагын тогтолцооны шилжилт

(a) байгууллага нь энэ дүрэмд заасан журамуудад нийцсэн болон дагаж мөрдөж байгааг бататгасан ИНД-119.207(b)(1)(ii) -д шаардсан дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгосон байна.

(b) Байгууллагын удирдлагын тогтолцооны журмууд нь үйл ажиллагааны хэмжээ, хүрээнээс хамаарч тухайн хамаарал бүхий журмууд байгууллагын бүх түвшинд ойлгомжтой бөгөөд хэрэгжсэн, хадгалагдаж байгааг бататгасан хангалттай, дэлгэрэнгүй байх ёстой.

(c) Энэ зүйлийн (e)-д зааснаас бусад тохиолдолд, байгууллагын удирдлагын тогтолцоо нь дараах зүйлийг агуулсан байна:

- (1) ИНД-12-ийн дагуу шинжлэн шалгах үйл ажиллагааны журмыг багтаасан аюулгүй ажиллагааны бодлого болон бодлогын журам; болон,
- (2) тогтолцооны хүрээнд оршиж буй асуудлыг илрүүлэх, эсхүл асуудал үүсгэж болзошгүй шалтгааныг тогтоох, ажиллагсдын болон үйлчлүүлэгчдийн мэдээлэл, зөрчил дутагдлын тухай илтгэл зэргийг багтаасан журам; болон,
- (3) тогтолцооны хүрээнд илэрсэн аливаа асуудал эсхүл болзошгүй асуудлууд:
 - (i) засаж залруулагдсан; болон,
 - (ii) засаж залруулах үйл ажиллагаа үр дүнтэй болсныг шалгах журам; болон,
- (4) байгууллагын хөтөлбөр болон журмууд түүний аюулгүй ажиллагааны бодлогын тогтоосон зорилгод хүрснийг шалгах журам; болон,
- (5) байгууллагын удирдлага энэ дүрмийн шаардлагуудыг хангахад үр дүнтэй хэвээр байгааг бататгах дараах зүйлүүдийг багтаасан журам:
 - (i) тогтмол үнэлж дүгнэх төлөвлөгөө; болон,
 - (ii) үнэлж дүгнэлтийн үр дүн болон илэрсэн асуудлыг засаж залруулах аливаа үйл ажиллагааг багтаасан ажилтнуудад тогтмол мэдээлэл өгөх.

(d) Байгууллагын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтан нь аюулгүй ажиллагаанд хамааралтай аливаа асуудлаар байгууллагын гүйцэтгэх захиралтай шууд харьцана.

(e) Энэ зүйлийн (c)-д заасан заалт дараах үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулахаар төлөвлөж байгаа агаарын тээвэрлэгчид хамаарахгүй:

- (1) үйл ажиллагааны тодорхойлолтонд нийт гурав болон түүнээс цөөн агаарын хөлөг бичигдсэн; болон,
- (2) Нийт хоёр болон түүнээс цөөн баазтай.

(f) Дүрмийн энэ заалт 2021 оны 02 сарын 01 хүртэл хүчинтэй.

ХАВСРАЛТ "А". АРИЛЖААНЫ АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэ хавсралтаар 119.51(b)(1)(i), (ii), (iii), (iv)-ийн дагуу үүрэг хариуцлага хүлээсэн удирдах албан тушаалтны мэргэшил, дадлага туршлагад тавигдах шаардлагыг тодорхойлно.

А.1 Агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа	
Шаардагдах баримт бичиг	Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй
Агаарын хөлгийн даргын дадлага туршлага	ИНД-121-ийн үйл ажиллагааны хүрээнд 3 жил агаарын хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай
Удирдан зохион байгуулах дадлага туршлага	Үйл ажиллагааны хяналтын нэгжид 3 жил ажилласан

	ИНД 125-ийн үйл ажиллагаа		ИНД 135-ийн үйл ажиллагаа
	Олон нисгэгчтэй	Нэг нисгэгчтэй	
Шаардагдах баримт бичиг	Агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэх	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх	Хавсралт Б-ээс харна уу
Агаарын хөлгийн даргын дадлага туршлага	ИНД-121, 125, 135-ийн үйл ажиллагааны хүрээнд 3 жил агаарын хөлгийн даргаар ниссэн дадлага	ИНД-121, 125, 135-ийн үйл ажиллагааны хүрээнд 3 жил агаарын хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай эхсүл	Хавсралт Б-ээс харна уу

	туршлагатай эсхүл		
Удирдан зохион байгуулах дадлага туршлага	Үйл ажиллагааны хяналтын нэгжид 3 жил ажилласан	Үйл ажиллагааны хяналтын нэгжид 3 жил ажилласан	Хавсралт Б-ээс харна уу

А.2 Нисэх багийн ур чадвар, сургалтын үнэлгээ хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД-121-ийн үйл ажиллагаа	
Шаардагдах баримт бичиг	Холбогдох зэрэглэл бүхий агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй
Ур чадварын хадгалалт	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэж байгаа
Experience	ИНД-121, 125, 135-ийн үйл ажиллагааны хүрээнд 3 жил агаарын хөлгийн даргаар ниссэн дадлага туршлагатай болон сургалт болон шалгалт хийсэн 2 жилийн дадлага туршлагатай.

	ИНД 125-ийн үйл ажиллагаа		ИНД 135-ийн үйл ажиллагаа
	Олон нисгэгчтэй	Нэг нисгэгчтэй	
Шаардагдах баримт бичиг	Холбогдох зэрэглэл бүхий агаарын тээвэрлэгчийн нисгэгчийн үнэмлэхтэй	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх	Хавсралт Б-ээс харна уу
Ур чадварын хадгалалт	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэж байгаа	Үйл ажиллагаа эрхлэгчийн аль нэг агаарын хөлгийн даргаар нислэг үйлдэж байгаа	Хавсралт Б-ээс харна уу

Түүнчлэн хэрэв тухайн этгээд нь 1999 оноос өмнө Даргаас олгосон агаарын тээврийн үйл ажиллагааны зөвшөөрлийн хүрээнд эсхүл Дарга хүлээн зөвшөөрөх адил маягийн агаарын тээврийн үйл ажиллагааны зохих дадлага туршлагатай бол ИНД-121, ИНД-125, ИНД-135-ийн үйл ажиллагаанд шаардагдах дадлага туршлагад тавигдах шаардлагад нийцэж байгаа талаар тухайн этгээдэд үнэлэлт өгч болно.

А.3 Техник үйлчилгээг удирдах, хянах удирдах албан тушаалтан

А.3.1 ИНД-121-ийн үйл ажиллагаа

(а) ИНД-121-ийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах байгууллагад техник үйлчилгээг удирдах болон хянах үйл ажиллагааг хариуцсан удирдах албан тушаалтан нь дараах шаардлагыг хангасан байна.

- (1) Байгууллагын ерөнхий зааврын техник үйлчилгээтэй хамаарал бүхий хэсгийн болон ИНД-121-ийн техник үйлчилгээтэй холбогдол бүхий заалтуудын талаар бүрэн мэдлэгтэй; болон,
- (2) энэ зүйлийн (b)-д заасан шаардлагуудыг хангасан; болон,
- (3) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргагчийн техник үйлчилгээг төлөвлөх, хянах үйл ажиллагааг гүйцэтгэх чадварыг тодорхойлох аливаа үзлэг шалгалт эсхүл сорилыг гүйцэтгүүлэх чадвартай.

(b) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан удирдах албан тушаалтан нь

- (1) дараах шаардлагуудыг хангасан байна:
 - (i) Зохих зэрэглэл бүхий агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхээзмшигч эсхүл эзэмшиж байсан эсхүл Дарга хүлээн зөвшөөрөхүйц адил төрлийн үнэмлэхтэй; болон,
 - (ii) Тухайн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөгтэй адил багтаамжтай болон адил маягийн агаарын хөлгийн техник үйлчилгээн дээр таваас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай; болон,
 - (iii) Хоёроос доошгүй жил хяналтын албан тушаалд ажилласан дадлага туршлагатай байх баэнэ дадлага туршлагыг энэ зүйлийн (b)(1) хэсэгт шаардсан таван жилийн хүгацаанд олж авсан байж болно.
- (2) дараах шаардлагуудыг хангасан байна:
 - (i) инженерийн мэргэжилтэй эсхүл нисэхийн, механикийн, цахилгааны чиглэлийн адил төстэй мэргэжилтэй; болон,

- (ii) Агаарын хөлөг дээр таваас доошгүй жил ажилласан дадлагатуршлагатай ба энэ дадлага туршлагыг техник үйлчилгээг хянах, төлөвлөх, инженерингийн боловсруулалт хийх эсхүл цехийн орчинд олж авсан байж болно.
- (iii) Зургаан сараас доошгүй хугацаагаар агаарын хөлгийн техник үйлчилгээний ажлыг гүйцэтгэсэн практик туршлагатай ба тухайн дадлага туршлагыг энэ зүйлийн (2)(ii) хэсэгт заасан таваас доошгүй жил ажилласан дадлага туршлагын явцад олж авсан байж болно.
- (iv) Хяналтын албан тушаалд хоёр жилээс доошгүй ажилласан дадлага туршлагатай ба энэ дадлага туршлагыг энэ зүйлийн (2)(ii) хэсэгт заасан таваас доошгүй жил ажилласан дадлага туршлагын явцад олж авсан байж болно.

(с) Энэ зүйлийн (b)(1)(ii) болон (b)(2)(ii)-д заасан дадлага туршлагын шаардлагыг Хууль болон ИНД-141 эсхүл ИНД-147-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагын зөвшөөрөл дор хийгдсэн, Дарга хүлээн зөвшөөрсөн сургалтуудаар дамжуулан хүлээн зөвшөөрч болно.

А.3.2 ИНД-125-ийн үйл ажиллагаа

(а) ИНД-125-ийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах байгууллагад техник үйлчилгээг удирдах болон хянах үйл ажиллагааг хариуцсан удирдах албан тушаалтан нь дараах шаардлагыг хангасан байна.

- (1) Байгууллагын ерөнхий зааврын техник үйлчилгээтэй хамаарал бүхий хэсгийн болон ИНД-121-ийн техник үйлчилгээтэй холбогдол бүхий заалтуудын талаар бүрэн мэдлэгтэй; болон,
- (2) энэ зүйлийн (b)-д заасан шаардлагуудыг хангасан; болон,
- (3) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргагчийн техник үйлчилгээг төлөвлөх, хянах үйл ажиллагааг гүйцэтгэх чадварыг тодорхойлох аливаа үзлэг шалгалт эсхүл сорилыг гүйцэтгүүлэх чадвартай.

(b) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан удирдах албан тушаалтан нь:

- (1) энэ зүйлийн А.3.1-ийн шаардлагыг хангасан; эсхүл,
- (2) дараах шаардлагуудыг хангасан байна:
 - (i) Хууль болон ИНД-66-ийн дагуу олгогдсон зохих зэрэглэл бүхий агаарын хөлгийн техник үйлчилгээний ажилтны үнэмлэхтэй эсхүл Дарга хүлээн зөвшөөрөхүйц адил төрлийн үнэмлэхтэй; болон,

- (ii) Тухайн байгууллагын үйл ажиллагаандаа ашиглаж байгаа агаарын хөлөгтэй адил багтаамжтай болон адил маягийн агаарын хөлгийн техник үйлчилгээн дээр гурваас доошгүй жил ажилласан дадлага туршлагатай; болон,
- (iii) Нэгээс доошгүй жил агаарын хөлгийг техник үйлчилгээнээс гаргасан дадлага туршлагатай байх ба энэ дадлага туршлагыг энэ зүйлийн (b)(2)(ii) хэсэгт шаардсан гурван жилийн хугацаанд олж авсан байж болно; эсхүл,
- (3) Тухайн байгууллагын үйл ажилгаандаа ашиглаж байгаа агаарын хөлөгтэй адил багтаамжтай болон адил маягийн агаарын хөлгийн техник үйлчилгээг таваас доошгүй жил хянах, удирдах болон нислэгт тэнцэх чадварын хадгалалтын хариуцаж ажилласан дадлага туршлагыг оролцуулаад Дарга хүлээн зөвшөөрөхүйц дадлага туршлагатай байх.
- (c) Энэ зүйлийн (b)(2)(ii)-д заасан дадлага туршлагын шаардлагыг Хууль болон ИНД-141 эсхүл ИНД-147-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагын зөвшөөрөл дор хийгдсэн, Дарга хүлээн зөвшөөрсөн сургалтуудаар дамжуулан хүлээн зөвшөөрч болно.

А4. Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД 121, 125, 135-ийн үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй ажиллагааны тогтолцооны холбогдох арга барилыг эзэмшсэн байх. Аюулгүй ажиллагааны болон ИНД-ийн зохих мэдлэгтэй байх.
Дадлага туршлага	Байгууллагын үйл ажиллагаа, аюулгүй ажиллагааны тогтолцоотой холбогдол бүхий дадлага туршлагатай.

ХАВСРАЛТ "Б". ЕРӨНХИЙ ЗОРИУЛАЛТЫН НИСЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИЙН ГЭРЧИЛГЭЭ ЭЗЭМШИГЧИЙН УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Энэ хавсралтаар 119.101(b)(1)(i), (ii), (iii), (iv)-ийн дагуу үүрэг хариуцлага хүлээсэн удирдах албан тушаалтны мэргэшил, дадлага туршлагад тавигдах шаардлагыг тодорхойлно.

В.1 Агаарын тээврийн үйл ажиллагаа хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД 135-ийн үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй эсхүл 3-аасцөөн баазтай
Шаардагдах баримт бичиг	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх
Агаарын хөлгийн даргын дадлага туршлага	ИНД 135-ийн үйл ажиллагааны хүрээнд агаарын хөлгийн даргаар 3 жил болон Дарга хүлээн зөвшөөрөхүйц ижил, төстэй маягийн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд ашиглах ижил төрлийн агаарын хөлөг дээр 750 цагийн; болон хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол 75 цагийн бодит эсхүл дуураймал нислэгийн; эсхүл ↓	Дарга хүлээн зөвшөөрөхүйц ижил, төстэй маягийн нислэгийн үйл ажиллагаа гүйцэтгэхэд ашиглах ижил төрлийн агаарын хөлөг дээр 500 цагийн; болон хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол 75 цагийн бодит эсхүл дуураймал нислэгийн; эсхүл ↓
Удирдан зохион байгуулах дадлага туршлага	Гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаанд тохирох Дарга хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн дадлага туршлагыг оролцуулаад үйл ажиллагааны хяналтын нэгжид 3 жил ажилласан.	Гүйцэтгэх нислэгийн үйл ажиллагаанд тохирох Дарга хүлээн зөвшөөрөхүйц нислэгийн дадлага туршлагыг оролцуулаад үйл ажиллагааны хяналтын нэгжид 2 жил ажилласан.

Эдгээр удирдах ажилтнуудын дадлага туршлагад тавигдах шаардлагуудыг үнэлэхдээ Дарга дараах зүйлүүдийг харгалзан үзэж болно:

- (а) Агаарын хөлгийн даргын шаардлага хангах удирдах албан тушаалтны хувьд Дарга цэргийн эсхүл адил төстэй үйл ажиллагааг оролцуулан ижил маягийн нислэгийн үйл ажиллагааны эсхүл ижил үйл ажиллагааны орчин, тоног төхөөрөмж болон агаарын хөлгийн конфигурацтай нислэгийн үйл ажиллагааны туршлагыг харгалзан үзэж болно.
- (б) менежерийн дадлага туршлага хангах удирдах албан тушаалтны хувьд Дарга нислэгийн үйл ажиллагааны хяналтын дадлага туршлага эсхүл цэргийн болон адил төстэй агаарын тээврийн үйл ажиллагааны дадлага туршлагыг харгалзан үзэж болно.

В.2 Нисэх багийн ур чадвар, сургалтын үнэлгээ хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД 135-ийн үйл ажиллагаа		
	3-аас олон агаарын хөлөгтэй эсхүл 2-оос олон баазтай	4-өөс цөөн агаарын хөлөгтэй эсхүл 3-аасцөөн баазтай
Шаардагдах баримт бичиг	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх	Хэрэв үйл ажиллагаанд хэрэглэлийн нислэгийн дүрмээр үйлдэх нислэг орж байгаа бол хэрэглэлийн зэрэглэл бүхий коммерийн нисгэгчийн үнэмлэх
Ур чадварын хадгалалт	Агаарын тээвэрлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нисч байгаа	Агаарын тээвэрлэгчийн аль нэг маягийн агаарын хөлгийн даргаар нисч байгаа
Дадлага туршлага	ИНД-135-ийн хүрээнд агаарын хөлгийн даргаар 3 жил ниссэн болон сургалт болон шалгах 2 жилийн дадлага туршлагатай	

В.3 Техник үйлчилгээг удирдах, хянах удирдах албан тушаалтан

а) ИНД-135-ийн хүрээнд агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах байгууллагад техник үйлчилгээг удирдах болон хянах үйл ажиллагааг хариуцсан удирдах албан тушаалтан нь дараах шаардлагыг хангасан байна.

(1) Байгууллагын ерөнхий зааврын техник үйлчилгээтэй хамаарал бүхий хэсгийн болон ИНД-135-ийн техник үйлчилгээтэй холбогдол бүхий заалтуудын талаар зохих мэдлэгтэй; болон,

(2) энэ зүйлийн (b)-д заасан шаардлагуудыг хангасан; болон,

(3) Дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өргөдөл гаргагчийн техник үйлчилгээг төлөвлөх, хянах үйл ажиллагааг гүйцэтгэх чадварыг тодорхойлох аливаа үзлэг шалгалт эсхүл сорилыг гүйцэтгүүлэх чадвартай.

(б) Энэ зүйлийн (а) хэсэгт заасан удирдах албан тушаалтан нь:

(1) энэ зүйлийн А.3.1-ийн шаардлагыг хангасан; эсхүл,

(2) энэ зүйлийн А.3.2-ийн шаардлагыг хангасан; эсхүл

(3) Тухайн байгууллагын Үйл ажиллагааны тодорхойлолтод нийт 3 буюу түүнээс цөөн агаарын хөлөгтэй болон 2 болон түүнээс цөөн баазтай агаарын тээврийн үйл ажиллагаа

явуулах эсхүл явуулж байгаа байгууллагын хувьд агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадвартайг бататгах техник үйлчилгээ болон техник үйлчилгээний хөтөлбөрт шаардсан аливаа техник үйлчилгээ зохих хэмжээнд хийгдэх талаар хангалттай мэдлэгтэй байна. (в) Энэ зүйлийн (b)(3)-д заасан мэдлэгт тавигдах шаардлагыг Хууль болон ИНД-141 эсхүл ИНД-147-ийн дагуу гэрчилгээжсэн сургалтын байгууллагын эрхийн хүрээнд хийгдсэн Дарга хүлээн зөвшөөрсөн зааврын хүрээнд явагдсан сургалтуудаар хангаж болно.

В.4 Аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах албан тушаалтан

ИНД 135-ийн үйл ажиллагаа	
Ур чадвар	Аюулгүй ажиллагааны тогтолцооны холбогдох арга барилыг эзэмшсэн болохоо нотлох. Аюулгүй ажиллагааны удирдлагын болон ИНД-ийн зохих мэдлэгтэй байх.
Дадлага туршлага	Байгууллагын үйл ажиллагаа, аюулгүй ажиллагааны тогтолцоотой холбогдол бүхий дадлага туршлагатай.